



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033

Утас: (976) 7035 9826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.04.14 № 195
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ТАМГЫН ГАЗАРТ

“Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудитын тайлан, судалгааг хүргүүлж байна.

Хавсралт хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

П.ПҮРЭВЛХАГВА



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/106

Баян-Өндөр сум

**Аудитын тайлан баталгаажуулах
тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсэг, 2025 оны А/161 дүгээр тушаалаар баталсан "Аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны журам"-ын 4.1 дэх хэсэг, 2025 оны А/175 дугаар тушаалаар баталсан "Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар, Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Хотын захирагчийн албанд тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /В.Жавзмаа/-т үүрэг болгосугай.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мэдээллийг статистик мэдээний бүртгэлд бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг ахлах аудитор /В.Жавзмаа/-т даалгасугай.
5. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Б.Зоригтбаяр/-д зөвлөсүгэй.
6. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2026 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер Б.Буян-Ундрах, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор А.Лхагвагэрэл, Ж.Наранчимэг нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.ПҮРЭВЛХАГВА



612501011

Орхон аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын 2026
оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/06
дугаар тушаалын хавсралт

6117143690
Ф А А 0073 9042906

“Улс төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”
гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

/ мянган төгрөгөөр /

Дугаар	Зөрчлийн товч утга	Дүн	Шийдвэр	Хариуцах байгууллага
183/А1460335 ОРА-2026/05-13-ШТА-НА	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал барих ажилд орон нутгийн төсвөөс 2,256.7 сая төгрөгөөр төсөв баталж, зураг төсөвт тухайн төсөвт магадлал хийлгээгүй байн.	2,256.7	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга
184/А1460335 ОРА-2026/05-13-ШТА-НА	4 төсөл, арга хэмжээ гүйцэтгэгч ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн.		Албан шаардлага	Хотын захирагчийн алба
185/А1460335 ОРА-2026/05-13-ШТА-НА	Наран багийн соёлын төвийн барилга нь 2019 онд эхэлсэн боловч одоо болтол дуусаагүй, барьсан барилга байгууламжийн зарим хэсэг эвдэрч, дахин хийж гүйцэтгэх шаардлага үүссэн.		Албан шаардлага	Аймгийн Засаг дарга
Нийт дүн		2,256.7		

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 45.5 хувь нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж дууссан байна.



Аудитын код: ОРА-2026/05-13-ШТА-НА

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2026 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn
Аудитор: А.Лхагвагэрэл
Утас: 70357955 Цахим хаяг: lkhagvagerela@audit.gov.mn
Аудитор: Ж.Наранчимэг
Утас: 70357955 Цахим хаяг: naranchimegi@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн товъёг	2
Дүрслэлийн товъёг.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	6
БҮЛЭГ 1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна	8
1.1. Төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, ач холбогдлоор эрэмбэлж, олон нийтээр хэлэлцүүлэн, үе шаттай хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаагүй байна.	8
1.2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөөр байна.	9
БҮЛЭГ 2. Орхон аймгийн Засаг даргад 2025 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний эрх шилжээгүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.	10
2.1. Орхон аймгийн Засаг даргад 2018-2024 онд эрх шилжиж, он дамжин хэрэгжиж буй 5 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулах шаардлага үүсээгүй байна.....	10
2.2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх талаар 2025 онд гомдол гараагүй байна.	11
БҮЛЭГ 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 54.5 хувь нь төлөвлөсөн хугацаандаа дуусаагүй, зарим төсөл, арга хэмжээ зогссон нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна.	11
3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 54.5 хувь нь төлөвлөсөн хугацаандаа дуусаагүй, зарим төсөл, арга хэмжээ зогссон байна.	11
3.2 Барилга байгууламжийн үе шат бүрд хэрэгжиж буй захиалагчийн техник хяналтын үр нөлөөг сайжруулж, хариуцлагатай ажиллуулах шаардлагатай байна.	16
3.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон эрх шилжээгүй хөрөнгийг бүртгэх шийдвэр гараагүй, зарим хөрөнгийг ашиглаж эхлээгүй нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.	20
АУДИТЫН ДҮГНЭЛТ:.....	21
ЗӨВЛӨМЖ:.....	22
Холбогдох байгууллагын санал:	23

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орхон аймагт улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталсан төсөл, арга хэмжээ	6
Хүснэгт 2	Орхон аймагт эрх шилжсэн төсөл, арга хэмжээний эхэлсэн хугацаа, явц	6-7
Хүснэгт 3	Орхон аймгаас улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал	8
Хүснэгт 4	Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа шалгаруулалт	10-11
Хүснэгт 5	Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний гэрээ сунгасан болон хэрэгжээгүй шалтгаан	12
Хүснэгт 6	Эрх шилжээгүй төсөл, арга хэмжээний гэрээ сунгасан тоо, хэрэгжилт	13
Хүснэгт 7	Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний өмчийн бүртгэл	20

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний 2025 оны төсөв, санхүүжилт	7
Дүрслэл 2	Эрх шилжээгүй төсөл, арга хэмжээний явц	7
Дүрслэл 3	Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний гэрээ сунгасан тоо	11

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/179 дүгээр тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө"-ний дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ, Хотын захирагчийн алба зэрэг холбогдох байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын

байгууллагаас аудит хийх журам, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр;
- Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай;
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”;
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

**Аудит хийхэд
учирсан хүндрэл
бэрхшээл**

- бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2023 оны А/261, 2025 оны А/106 дугаар тушаалаар тус тус баталсан баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”;
 - Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”;
 - Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
 - Барилга байгууламжийн үнэ бүрдэл, төсөв зохиох норм, дүрэм, стандарт;
 - Батлагдсан зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд
 - Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор А.Лхагвагэрэл, Ж.Наранчимэг нар 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитыг хийхэд хүндрэл бэрхшээл үүсээгүй.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан ба хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 29 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 505, тухайн оноос эхлэн хэрэгжих 106, нийт 8,735.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 611 төсөл, арга хэмжээг 2,914.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Үүнээс Орхон аймагт өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 11, 2025 оноос эхлэн хэрэгжих 1, нийт 77.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг 23.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Нийт санхүүжилтийн 91.6 хувийг 11 барилга, байгууламж, 8.4 хувийг тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээ эзэлж байгаа ба барилга байгууламжийн 11 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна.

Орхон аймагт хэрэгжих 12 төсөл, арга хэмжээнээс Засаг даргад эрх шилжсэн 5, эрх шилжээгүй 7 төсөл, арга хэмжээ байгаа ба 11 ТАХ нь он дамжин хэрэгжжээ. Эдгээр төсөл, арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах байдлаар доор харуулав.

Хүснэгт №1 Орхон аймагт улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталсан төсөл, арга хэмжээ

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	эрх шилжээгүй		эрх шилжсэн	
		шинэ	шилжих	шинэ	шилжих
1	Боловсролын сайд		1		5
2	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд		5		
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	1			
Нийт		1	6	-	5

Тайлант онд шинээр хэрэгжихээр төлөвлөсөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад хамаарах 1 төсөл, арга хэмжээ Орхон аймагт хэрэгжээгүй байна.

Орхон аймгийн Засаг даргад эрх шилжсэн 5 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжиж байна.

Хүснэгт №2 Орхон аймагт эрх шилжсэн төсөл, арга хэмжээний эхэлсэн хугацаа, явц

№	хуулийн дугаар	ТАХ-ний нэр	Гэрээ байгуулсан огноо
1	XII.1.1.10	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/	
2	XII.1.1.18	Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/	
3	XII.1.1.168	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/	

4	XII.1.1.112	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/
5	XII.1.1.155	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/


Эрх шилжсэн, он дамжин хэрэгжиж буй 5 төсөл, арга хэмжээнээс 2 нь 2022 оноос хойш ажил хийгдээгүй зогссон, 3 төсөл, арга хэмжээ нь 2025 оны байдлаар 30-95 хувийн гүйцэтгэлтэй, тайлант онд 9,609.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна

Дүрслэл №1 Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний 2025 оны төсөв, санхүүжилт



Эрх шилжээгүй 6 төсөл, арга хэмжээнээс 5 нь 2025 онд бүрэн дуусаж, 1 нь шилжин хэрэгжиж байгаа ба санхүүжилт, хөрөнгийн бүртгэлийг Боловсролын сайд болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд хариуцаж байна.

Дүрслэл №2 Эрх шилжээгүй төсөл, арга хэмжээний явц



БҮЛЭГ 1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

1.1. Төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, ач холбогдлоор эрэмбэлж, олон нийтээр хэлэлцүүлэн, үе шаттай хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаагүй байна.

УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” - ийг, 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-г тус тус баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар баталсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчаас орон нутагт эрх шилжүүлсэн өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 41.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, Орхон аймаг, Эрдэнэт хотыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн байна.

Аймгийн Засаг дарга 2 сум, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдээс 23 санал авч нэгтгэн, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд холбогдох журам, аргачлалын дагуу нөхцөл байдлыг үнэлж, 22.5-149.5 оноо өгч эрэмбэлжээ. Харин тухайн жилийн төсвийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн санал цахим системд хангалтгүй, хэрхэн хэлэлцсэн талаарх мэдээллийг тусгаагүй байна.

Орхон аймгийн Засаг даргаас улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 23 төсөл, арга хэмжээний саналыг Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд тусгуулахаар 10 төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Хүснэгт №3 Орхон аймгаас улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал

№	Салбар	Төсөл, арга хэмжээ			Үүнээс:	
		тоо	төсөвт өртөг	ТЭЗҮ, зураг төсөл	барилга байгууламж	тоног төхөөрөмж
1	боловсрол	12	109,944.8		106,444.8	3,500.0
2	дэд бүтэц	4	34,189.0	550.0	31,139.0	2,500.0
3	эрүүл мэнд	2	11,319.8		11,319.8	
4	соёл, спорт	3	13,460.2		13,460.2	
5	төрийн удирдлага	2	496.7		387.5	109.2
	Дүн	23	169,410.5	550.0	162,751.3	6,109.2

Төлөвлөсөн саналын 4.3 хувийг ТЭЗҮ, зураг төсөв, 13.0 хувийг тоног төхөөрөмж, 82.7 хувийг барилга байгууламж эзэлж байна.

Цахим системийн төсөл, арга хэмжээ болон дараа онд хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээ

төлөвлөөгүй бөгөөд боловсролын салбарын хувьд нэг маягийн зураг, төсвийг ашиглаж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд журам аргачлалын дагуу төсөл, арга хэмжээ бүрийн талаарх ерөнхий болон дэлгэрэнгүй мэдээллийг мэдээлж, ихэнх төсөл, арга хэмжээг бүрэн үнэлээгүй, холбогдох мэдээлэл, судалгааг хийгээгүй байна.

Тухайлбал төсөл, арга хэмжээтэй холбоотой бусад шийдвэр мэдээллийг бүрэн мэдээлээгүй, иргэдийн саналыг үнэлж эрэмбэлсэн байдал тодорхойгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй байна. Энэ нь аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсүүд, холбогдох төсвийн байгууллагуудын ажлын уялдаа холбоогүйгээс шалтгаалан, нэгдсэн судалгаанд үндэслэн дүн шинжилгээ хийдэггүй, албан хаагчдын хариуцлага сул байгааг илтгэж байна гэж үзлээ. Энэ нь Төсвийн тухай 29¹.1¹, 29¹.2.4², 29¹.2.6³-т заасан шалгуурыг хангахгүй байна.

Мөн Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.1.1⁴, 2.3.1.3⁵-т заасан аймгийн Засаг даргын чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Иймд аймгийн хэмжээнд төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, ач холбогдлоор эрэмбэлж, олон нийтээр хэлэлцүүлэн, үе шаттай хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай.

1.2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөөр байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар баталсан Орхон аймагт эрх шилжиж, он дамжин хэрэгжиж буй 5 төсөл, арга хэмжээ нь архитектур төлөвлөлт, зургийн даалгаврын дагуу хийсэн зураг, төсөл, магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан бөгөөд өмнөх онуудад хийсэн аудитаар шалгасан төсөл, арга хэмжээнүүд байна.

“Орхон аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах” төсөл, арга хэмжээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад баталсан ба Орхон аймгаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах санал хүргүүлээгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын тооцоолол хийгээгүй байна.

Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/ 14,920.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг 2024-2026 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн боловч, санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаатай

¹ 29¹.1 Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

² 29¹.2.4 урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх

³ 29¹.2.6 олон нийтээр хэлэлцүүлсэн байх

⁴ 2.3.1.1 тухайн орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэх, эрэмбэлэх

⁵ 2.3.1.3 төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх

уялдуулан төсөвлөөгүйгээс батлагдсан төсөвт өртгийн 31.8 хувь буюу 4,738.6 сая төгрөгийг 2024 онд, 18.5 хувь буюу 2,764.2 сая төгрөгийг 2025 онд баталсан нь төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг бий болгож байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5⁶-д заасантай нийцэхгүй байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг, УИХ-ын 35 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг баталсан нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын нэгтгэсэн тоон мэдээлэлд хамааралтай байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд журам аргачлалын дагуу төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хэт ерөнхий байдлаар тусгаснаас, хэмжих боломжгүй байна.

БҮЛЭГ 2. Орхон аймгийн Засаг даргад 2025 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний эрх шилжээгүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

2.1. Орхон аймгийн Засаг даргад 2018-2024 онд эрх шилжиж, он дамжин хэрэгжиж буй 5 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулах шаардлага үүсээгүй байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан 12 төсөл, арга хэмжээнээс 5 нь 2018-2024 онд Орхон аймгийн Засаг даргад эрх шилжсэн байна. Эдгээр төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №4 Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа шалгаруулалт

Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Тендерийг анх зарласан огноо	Тендер шалгаруулалт зохион байгуулсан удаа	ХАА-нд мөрдөгдсөн журам	Гэрээ байгуулах эрх олгосон огноо
Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/	Ажил	2024.10.16	1	НТШ	2024.11.25
Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/	Ажил	2024.08.30	1	НТШ	2024.10.10
Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/	Ажил	2019.05.22	1	НТШ	2019.07.03

⁶ 29.3.5 шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах

Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/	Ажил	2022.02.16	2	НТШ	2022.06.30
Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/	Ажил	2020.03.27	1	НТШ	2020.04.29

Эрх шилжсэн 5 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжсэн тул 2025 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулах шаардлага үүсээгүй.

2.2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх талаар 2025 онд гомдол гараагүй байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл, мэдээлэлд улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ байхгүй тул гомдол санал гараагүй, худалдан авах ажиллагаатай холбоотой хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

БҮЛЭГ 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 54.5 хувь нь төлөвлөсөн хугацаандаа дуусаагүй, зарим төсөл, арга хэмжээ зогссон нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна.

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 54.5 хувь нь төлөвлөсөн хугацаандаа дуусаагүй, зарим төсөл, арга хэмжээ зогссон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан 2025 онд өмнөх оноос шилжсэн 5 төсөл, арга хэмжээг 30,192.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр анх гэрээ байгуулсан хэдий ч ажлын явцад 2 төсөл, арга хэмжээний гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан гэрээний нийт дүнг 38,871.2 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн байна.

Дүрслэл №3 Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний гэрээ сунгасан тоо



Он дамжин хэрэгжүүлж буй 5 төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээний хугацааг тус бүр 1-5 удаа сунгасан байна.

Хүснэгт №5 Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний гэрээ сунгасан болон хэрэгжээгүй шалтгаан

№	Хуулийн дугаар	ТАХ-ний нэр	Гэрээ байгуулсан огноо	Хугацаа сунгасан гэрээний тоо	Дуусах огноо	Хуулиар баталсан хугацаанд хэрэгжээгүй шалтгаан
1	XII.1.1.10	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/	2024.12.04	Хугацаа сунгах гэрээ - 1 удаа	2026.10.09	Улсын төсвийн 2024-2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвт өртгийг хувааж баталсан. Ажлын явц 30%-ийн гүйцэтгэлтэй.
2	XII.1.1.18	Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/	2024.10.08	Хугацаа сунгах гэрээ - 1 удаа	2026.09.20	Улсын төсвийн 2024-2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвт өртгийг хувааж баталсан. Ажлын явц 40%-ийн гүйцэтгэлтэй.
3	XII.1.1.168	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/	2019.07.22	Хугацаа сунгах гэрээ - 3 удаа	2021.10.30	Улсын төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвт өртгийг хувааж, 2,500.0 сая төгрөг баталсан. 2021 оноос санхүүжилт батлагдаагүй. "Жам" ХХК-ийн 2,496.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан. 2026 онд төсөл, арга хэмжээг дуусгахаар тендер зарласан.
4	XII.1.1.112	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/	2022.07.08	Хугацаа сунгах гэрээ - 4 удаа Төсөв нэмсэн гэрээ - 1 Орон нутгаас төсөв нэмсэн гэрээ -1	2026.01.30	Улсын төсвийн 2022-2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвт өртгийг хувааж баталсан. Ажлын явц 95%-ийн гүйцэтгэлтэй. 2026.02.27-нд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажилласан боловч комиссын ирц бүрдээгүй, 14 хоног хойшилсон байна.
5	XII.1.1.155	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/	2020.10.29	Хугацаа сунгах гэрээ - 3 удаа Төсөв нэмсэн гэрээ 1, 2023.02.28	2022.08.30	Улсын төсвийн 2020-2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвт өртгийг хувааж, 2,000.0 сая төгрөг баталсан ба 2023 онд материалын үнийн өөрчлөлтөөр 589.6 сая төгрөг баталсан. 2026 онд төсөл, арга хэмжээг дуусгахаар тендер зарласан.

Орхон аймагт эрх шилжсэн 5 төсөл, арга хэмжээ нь 2025 онд бүрэн дуусахаар төлөвлөсөн ч 2 төсөл, арга хэмжээний гэрээг цуцалж 2026 онд худалдан авах ажиллагаа зарласан, 1 төсөл, арга хэмжээ нь 95 хувийн гүйцэтгэлтэй, үлдсэн 2 төсөл, арга хэмжээ нь 30-40 хувийн гүйцэтгэлтэй байна.

Эрх шилжээгүй 6 төсөл, арга хэмжээнээс 5 нь бүрэн дуусаж, 1 нь 2026 онд дамжин хэрэгжих төлөвлөгөөтэй байна.

Хүснэгт №6 Эрх шилжээгүй төсөл, арга хэмжээний гэрээ сунгасан тоо, хэрэгжилт

№	Хуулийн дугаар	Дэд төсөл, арга хэмжээний нэр	Гэрээ байгуулсан огноо	Хугацаа сунгасан гэрээний тоо	Дуусах огноо	Хуулиар баталсан хугацаанд дууссан эсэх, хэрэгжээгүй шалтгаан
1	XVI.1.36	Ф720 мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөлийн ажил /Орхон, Баян-Өндөр сум/	2022.07.01	Хугацаа сунгах гэрээ - 4 удаа	2025.12.30	Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан.
2	XVI.1.36	Төв дулаан, цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ус дулаан дамжуулах төв барих ажил /Орхон, Баян-Өндөр сум, Цагаан чулуут, Наран баг/	2022.06.29	Хугацаа сунгах гэрээ - 4 удаа	2025.12.30	Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан.
3	XVI.1.36	Эрх чөлөөний гудамжны уулзварын өргөтгөлийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /Орхон, Баян-Өндөр сум, Уурхайчин баг/	2022.09.02	Хугацаа сунгах гэрээ - 3 удаа	2025.11.01	Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан.
4	XVI.1.36	Ариутгах татуургын 3-р коллекторын төв шугам татах ажил /Орхон, Баян-Өндөр сум/	2022.04.18	Хугацаа сунгах гэрээ - 4 удаа	2025.12.15	Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан.
5	XVI.1.36	Төв дулааны цэвэр усны шугам, ус дулаан дамжуулах төвийн барилга, гадна инженерийн шугам сүлжээний ажил /Орхон, Баян-Өндөр сум, Их залуу баг/	2022.10.11	Хугацаа сунгах гэрээ - 1 удаа	2024.06.01	Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан.
6	XII.1.1.15	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2а хороолол/	2024.10.21	-	2025.12.31	Гэрээ 2024 оны 10-р сард байгуулж, талбайн ажлыг оройтож 2025 оны 7-р сард эхлүүлсэн.

Орхон аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 12 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 2025 онд 23,624.8 сая төгрөг баталснаас 16,106.0 сая төгрөгөөр санхүүжүүлж 68.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Эрх шилжүүлсэн 5 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээнд бодит ажлын гүйцэтгэлээр 9,609.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 2 төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгоогүй байна.

Захиалагчийн техник хяналтын зардалд 215.3 сая төгрөгийг Боловсролын сайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын данснаас шилжүүлсэн байна.

Төсөл, арга хэмжээг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн эсэхэд захиалагчийн хяналтыг эрх шилжсэн төсөл, арга хэмжээнд аймгийн “Хот

байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ, эрх шилжээгүй төсөл, арга хэмжээнд аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан захиалагчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээний дагуу хяналт хэрэгжүүлжээ.

Аудитаар Орхон аймагт хэрэгжиж буй 11 төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлэхэд зураг төсвийн дагуу гүйцэтгүүлээгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- “Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/” - гадна фасадын дулаалгыг зураг төсөвт зааснаас 100мм-ээр дутуу хийж, ус тусгаарлагч хийгээгүй байна.
- Ф720 мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөлийн ажил /Орхон, Баян-Өндөр сум/ - Нуман хаалга /арк/-ыг гүйцэтгэж дуусгаагүй байна.
- Төв дулаан, цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ус дулаан дамжуулах төв барих ажил /Орхон, Баян-Өндөр сум, Цагаан чулуут, Наран баг/ - гадна генераторыг холбоогүй, ус, дулаан дамжуулах төвийн дотор заслыг бүрэн дуусгаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан " Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.3.1⁷, 5.3.2⁸-д заасантай нийцэхгүй бөгөөд хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Иймд дутуу хийсэн ажлыг бүрэн гүйцэтгүүлж, гүйцэтгэлийг хүлээн авах зөвлөмж хүргүүлэв.

Мөн Ф720 мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөлийн ажил /Орхон, Баян-Өндөр сум/-ын зураг төсвийг бодитой судалгаанд үндэслээгүйгээс солих тулгуурын тоо хэмжээ болон шугамын холболтын цэгийг бүрэн тооцоогүй, тулгуурын ачааллыг тогтоогоогүй нь зураг төсөв шаардлага хангаагүйтэй холбоотой байна.

Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/ төсөл, арга хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаас 1,511.5 сая төгрөгийн төсвийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 сарын 09-ний өдрийн 03/40 дүгээр тогтоолоор баталж, гүйцэтгэлийг үндэслэн 1,023.7 сая төгрөг олгосон байна.

Тухайн ажлын төсвийг 2,256.7 сая төгрөгөөр тооцоолж, зураг төсөвт тооцоолсон тоосгон өнгөлгөө болон ашиг, магадалшгүй ажлын зардал 745.1 сая төгрөгийг хасаж, зөрүү 1,511.5 сая төгрөгөөр төсөвлөсөн байна.

Нэмэлт гэрээг 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр байгуулж, нэмэлт ажил буюу металл фасад хийхээр болсон бөгөөд тухайн төсөвт магадлал хийлгээгүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 25.5⁹-д заасантай нийцэхгүй байна.

⁷ 5.3.1 Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ

⁸ 5.3.2 Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4 заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана”

⁹ 25.5 Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ

Орхон аймгийн Засаг даргад эрх шилжсэн 5, 2025 онд төсөв батлагдаагүй 2, нийт 7 ТАХ-ний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж, зарим арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/, Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/ төсөл, арга хэмжээний гэрээг цуцалж, 2026 оны улсын төсөвт санхүүжилт батлуулан, 2026 онд дуусгахаар тендер зарласан,



- 2025 онд улсын төсөв батлаагүй Соёлын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Наран баг/ төсөл, арга хэмжээ нь 2019 онд эхэлсэн боловч одоо болтол дуусаагүй, барьсан барилга байгууламжийн зарим хэсэг эвдэрч, дахин хийж гүйцэтгэх шаардлагатай болсон байна. Орхон аймгийн Сум дундын анхан шатны шүүгчийн 2025 оны 02 сарын 26-ны өдрийн 312/Ш32025/01610 захирамжаар албадан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн байна.



- Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/ төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг 1 жилээр сунгасан боловч дуусаагүй байна. Орхон аймгийн Сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 10 сарын 28-ны өдрийн 1102 гүйцэтгэх хуудсаар эвлэрлийн гэрээг баталгаажуулсан ч эвлэрлийн гэрээг зөрчсөн байна.

Гүйцэтгэгч байгууллагаас 2025 онд аймгийн Засаг даргад ирүүлсэн албан бичиг, хүсэлтийг үндэслэн 3 төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг 4 удаа сунгасан байна.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 3 дугаар сургуулийн хичээлийн байрны түрээсийн асуудлыг шийдвэрлэхээр аймгийн Боловсролын газар, Уран хангай групп ХХК-ийн төлөөллүүд 2025 оны 12 сарын 09-ний өдөр хурал зохион байгуулж, 2025-2026 оны хичээлийн жилийн 1 дүгээр улирлын амралт эхлэхэд барилгын ажлыг дуусгах, 2025 оны 12 сарын 15-нд улсын урьдчилсан комисс ажиллуулах, гэрээний

дагуу ажиллаагүй тохиолдолд түрээсийн зардлыг “Уран хангай” групп ХХК хариуцах талаар хэлэлцэж, шийдвэрлэжээ.

Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/ төсөл, арга хэмжээний гэрээг сунгахдаа үүссэн нөхцөл байдал, үндэслэлийг бүрэн тодорхойлоогүй, гүйцэтгэгчийн 2025 оны 11 сарын 19-ний өдрийн 25/85 дугаар албан бичигт “... үлдэгдэл санхүүжилт 2026 он дамжих нь тодорхой болсон тул 2026 оны 1 сарын 30 хүртэл сунгаж өгч тусална уу” гэсэн хүсэлтийн дагуу сунгасан нь сургалтын зориулалтаар ашиглах байр, анги, танхим түрээсийн зардалд 2025 онд 281.6 сая төгрөг, 2026 оны 1 дүгээр улиралд 211.2 сая төгрөг төлж, үргүй зардлыг нэмэгдүүлсэн байна.

3.2 Барилга байгууламжийн үе шат бүрд хэрэгжиж буй захиалагчийн техник хяналтын үр нөлөөг сайжруулж, хариуцлагатай ажиллуулах шаардлагатай байна.

Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж, акт, фото зургаар баталгаажуулсан байна.

Орхон аймагт Боловсролын сайдаас эрх шилжсэн төсөл, арга хэмжээнд “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ захиалагчийн хяналтыг гэрээний дагуу төслийн талбайд үе шатны болон төлөвлөгөөт шалгалтыг хийж, барилга байгууламжийн үе шат бүрд актаар баталгаажуулсан байна.

Тус байгууллага нь хяналт шалгалтын тоон мэдээллийг нэгтгэж, тайлагнаагүй бөгөөд гүйцэтгэгч байгууллагын “барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл”, үе шатны актад тэмдэглэл үйлдсэн байна. Цаашид хөрөнгө оруулалтын ажил тус бүрээр хяналт хэрэгжүүлсэн судалгааг гарган, дүн шинжилгээ хийж, эрх бүхий албан тушаалтныг мэдээллээр хангах нь зүйтэй байна.

Аудитаар захиалагчийн хяналтын үр дүнг баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/ төсөл, арга хэмжээний зураг төсөвт гадна фасадыг хийж гүйцэтгэхдээ 3 үе шатаар /ус тусгаарлагч, 150мм чулуун хөвөн хавтан дулаалга, ус тусгаарлагч/ хийхээр тусгагдсан ч шууд чулуун хөвөн хавтан дулаалгыг 50мм зузаантай хийж ус тусгаарлагчийг 2 талд нь хийж өгөөгүй, “барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл”-ийн дэвтрийг хөтлөөгүй, барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ сунгаагүй байна.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газар

- Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/ төсөл, арга хэмжээний барилгын ажил эхэлсэн боловч барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг сунгаагүй байна.



- Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум Баянцагаан баг/” төсөл, арга хэмжээ нь 2023 онд гадна фасадын ажлыг дутуу гүйцэтгэсэн бөгөөд өрлөг тэгш бус хийсэн, гадна фасадын хөөс буулгаж дахин хийх шаардлагатайг 2024 онд хийсэн аудитаар тогтоосон. 2025 онд барилгын ажлыг үргэлжлүүлэн хийхдээ гадна фасадын хөөсийг буулгаагүй байна. Тухайн гадна фасадын хөөсний чанар алдагдаж, дахин засварлах нөхцөл үүсэж, үргүй зардал гарахаар байна.



- Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/ төсөл, арга хэмжээнд 2026 он 04 сарын 02-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж үүрэг даалгавар өгсөн байна. Гадна хаяавч, гадна тохижилт, гадна галын гидрант суурилуулаагүй, подвалын аврах гарцын саравч хийх зэрэг ажлыг бүрэн хийж дуусгаагүй, зураг төсөвт тусгасан материалын чанарыг бууруулж дээврийн ажлыг гүйцэтгэсэн байна.



Эдгээр нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.3.2¹⁰, 5.3.6¹¹-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Мөн Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын яам, Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яам, Боловсролын яамнаас эрх шилжээгүй төсөл, арга хэмжээнд аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь дангаар 22, улсын техник хяналтын улсын байцаагчтай 4, хангагч байгууллагуудтай хамтран 4, Барилгын хөгжлийн төвтэй хамтран 4, төслийн талбайд үе шатны болон төлөвлөгөөт, гэнэтийн хяналт шалгалтыг нийт 34 удаагийн давтамжтай хийж гүйцэтгэн, холбогдох баримт бичгээр баталгаажуулсан байна.

Зохиогчийн хяналтыг 2025 онд 3 төсөл, арга хэмжээнд нийт 10 удаа хийж, 2 зохиогчид хяналтын зардалд 39.4 сая төгрөгийг олгожээ.

Барилга байгууламжийн бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандартыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын материалын сорилт шинжилгээний лабораториор хянуулж, сорил, шинжилгээний дүнг ажлын гүйцэтгэлийн баримтад хавсаргасан байна. Аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын ажлын бетон, арматур, барилгын материалын хувьд стандартын шаардлага хангаагүй зөрчил үүсээгүй байна.

Харин Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон аймаг, Баян-Өндөр сум, Оюут баг, 2А хороолол/-ын төсөл, арга хэмжээний дундын гүйцэтгэлийг хяналтын инженер хянаж, үе шатны ажлыг захиалагч байгууллагын зөвшөөрөлгүй гүйцэтгэсэн, гарал үүсэл нь тодорхойгүй бараа материалыг сорил шинжилгээгээр баталгаажуулах шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тул санхүүжилтийн гүйцэтгэлийг баталгаажуулаагүй бөгөөд зөрчлийг арилгуулсан байна.

Аудитаар төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх явцад Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/ төсөл, арга хэмжээний гадна фасад хийх барилгын материалыг сорил шинжилгээгээр баталгаажуулаагүй байна. Иймд зураг төсөвт тусгасан барилгын материалыг шинжилгээгээр баталгаажуулж, стандартад нийцсэн эсэхийг тогтоон, холбогдох шийдвэрийг гаргаж ажиллах шаардлагатай байна.

Орхон аймагт улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дуусах 10 төсөл, арга хэмжээнээс 5 нь бүрэн хэрэгжиж дууссан ба ашиглагч талд хүлээлгэн өгч гэрээг дүгнэсэн байна.

¹⁰ 5.3.2 Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4-т заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана

¹¹ 5.3.6 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна

Аудитаар төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцыг тулгахад барилга байгууламжийн ашиглалтад оруулах комисс ажиллаж, үүрэг даалгавар өгч биелэлтийг тооцсон хэдий ч зарим зөрчил илэрлээ. Тухайлбал:


- Ф720 мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөлийн ажил /Орхон, Баян-Өндөр сум/ төсөл, арга хэмжээг шаардлага хангаагүй зураг төсвөөр хийж гүйцэтгэсэн, нуман хаалга /арк/-ыг гүйцэтгэж дуусгаагүй,
- Төв дулаан, цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ус дулаан дамжуулах төв барих ажил /Орхон, Баян-Өндөр сум, Цагаан чулуут, Наран баг/ төсөл, арга хэмжээний гадна генераторыг холбоогүй, ус дулаан дамжуулах төвийн дотор заслыг бүрэн дуусгаагүй байна.

Дээрх зөрчил илэрсэн нь комисс заавар журмын дагуу хяналт тавьж ашиглалтад хүлээн аваагүйг илтгэх бөгөөд үүрэг даалгаврын биелэлтийг хянаж, акт үйлдэж байх шаардлагатай байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс тусгайлан болон төлөвлөгөөт шалгалтыг хийгээгүй байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2023 оны 12 сарын 01-ний өдрийн С/49 дүгээр “Үндэсний стандарт шинээр батлах” тухай тушаалаар бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарын улсын хэмжээнд дагаж мөрдөх стандартыг боловсруулж баталсан.

Дээрх стандартын дагуу “Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч мэдээллийн самбарыг стандартад тавигдах шаардлагын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн бол бусад 5 төсөл, арга хэмжээнд мэдээллийн самбар байршуулаагүй, мэдээллийн самбарыг стандартад нийцүүлэн шинэчлээгүй байна.



Энэ нь Барилгын тухай хуулийн 37.1.2¹², Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.10¹³, 8.6.11¹⁴-д заасны дагуу барилга байгууламж болон үйл

¹² 37.1.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.10, 8.6.11-д заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаархи иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах

¹³ 8.6.10.мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл

¹⁴ 8.6.11.барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн, дүгнэлт

ажиллагааныхаа талаарх иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах заалттай нийцэхгүй байна.

Иймд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээнд хэрэглэх мэдээллийн самбарыг холбогдох стандарт, норм, дүрмийн дагуу байршуулсан эсэхэд захиалагч хяналт тавих шаардлагатай байна.

3.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон эрх шилжээгүй хөрөнгийг бүртгэх шийдвэр гараагүй, зарим хөрөнгийг ашиглаж эхлээгүй нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 11 төсөл, арга хэмжээнээс тухайн онд 31,988.5 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 5 ТАХ буюу 45.5 хувь нь хэрэгжиж дууссан байна.

Хэрэгжиж дууссан 5 төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргад эрх шилжээгүй аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэцтэй холбоотой бөгөөд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хөрөнгийн бүртгэл нь хамааралтай байна.

2025 оны байдлаар эрх шилжсэн, дуусаагүй 38,871.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 төсөл, арга хэмжээг 21,899.6 сая төгрөгөөр Орон нутгийн өмчийн газрын дуусаагүй барилга дансанд бүртгэсэн байна.

Хүснэгт №7 Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний өмчийн бүртгэл

№	Төсөл, арга хэмжээний нэр	Бүртгэлд тусгасан үнийн дүн	Бүртгэлд тусгасан байгууллагын нэр
1	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/	1,900.0	Орон нутгийн өмчийн газар
2	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/	12,793.5	Орон нутгийн өмчийн газар
3	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/	1,583.7	Орон нутгийн өмчийн газар
4	Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/	4,164.2	Орон нутгийн өмчийн газар
5	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/	1,458.2	Орон нутгийн өмчийн газар
	Нийт дүн	21,899.6	

2025 онд ашиглалтад хүлээн авсан Ф720 мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөлийн ажил /Орхон, Баян-Өндөр сум/-ын зураг төсөв бодитой хийгээгүйгээс өргөлтийн насост шугамын хоолой холбогдоход 36м дутуу, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн төв шугамд холбоход аркаар давуулах талбайгүйгээс холбох боломжгүй болж, шугамыг ашиглаж эхлээгүй байна.

Орхон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 11 төсөл, арга хэмжээний шалгуур

үзүүлэлтийг шинээр ашиглалтад орсон сургууль, цэцэрлэг, шинээр баригдсан шугамын урт, ус дулаан дамжуулах төвийн тоогоор хэмжихээр төлөвлөжээ. Харин бодлогын зорилт үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулж тайлагнаагүй, биелэлт бүрэн хангагдаагүй байтал бүрэн хэрэгжсэнээр тайлагнасан байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.3¹⁵, 2.3.1.5¹⁶-т заасантай нийцэхгүй байна.

Орхон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний хэрэгжилт зорилтдоо хүрээгүй бөгөөд 45.5 хувийн биелэлттэй байна.

2025 онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн 5 төсөл, арга хэмжээ бүрэн дуусаагүй, зарим төсөл, арга хэмжээний гэрээг цуцалж, худалдан авах ажиллагаа зарласан зэрэг нь хөрөнгө оруулалтаас иргэдэд хүрэх үр нөлөөг бууруулж, төлөвлөөгүй зардал гарахад нөлөөлж байна. Иймд бодлогын баримт бичигт тусгагдсан арга, хэмжээг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцож байх шаардлагатай байна.

Өмнөх аудитаар аймгийн Засаг даргад өгсөн 2 зөвлөмж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлагын биелэлтийг хянан үзэхэд аудитын шийдвэрийн хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Анхан шатны шүүхийн шийдвэр гарсан төсөл, арга хэмжээг дуусгах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт шүүхийн шийдвэр гүйцэтгэх үе шатандаа хэрэгжиж байна.

Аудитаар илэрсэн 2,256.7 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах 2,256.7 сая төгрөгийн 3 албан шаардлага, 6 зөвлөмж хүргүүлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, ач холбогдлоор эрэмбэлж, олон нийтээр хэлэлцүүлэн, үе шаттай хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.
- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөөр байна.
- Орхон аймгийн Засаг даргад 2018-2024 онд эрх шилжиж, он дамжин хэрэгжиж буй 5 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулах шаардлага үүсээгүй байна.
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх талаар 2025 онд гомдол гараагүй байна.

¹⁵ 2.3 Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ

¹⁶ 2.3.1.5 төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлэн тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, хариуцах

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 54.5 хувь нь төлөвлөсөн хугацаандаа дуусаагүй, зарим төсөл, арга хэмжээ зогссон байна.
- Барилга байгууламжийн үе шат бүрд хэрэгжиж буй захиалагчийн техник хяналтын үр нөлөөг сайжруулж, хариуцлагатай ажиллуулах шаардлагатай байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон эрх шилжээгүй хөрөнгийг бүртгэх шийдвэр гараагүй, зарим хөрөнгийг ашиглаж эхлээгүй нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

- Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг иж бүрэн, тооцоо судалгаа хийж, эрэмбэлэн, олон нийтээр хэлэлцүүлж байх.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсвийг бодитой тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн зохиосон эсэхэд хяналт хэрэгжүүлэх.
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан Ф720 мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөлийн ажил /Орхон, Баян-Өндөр сум/ - нуман хаалга /арк/-ыг гүйцэтгээгүй, Төв дулаан, цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ус дулаан дамжуулах төв барих ажил /Орхон, Баян-Өндөр сум, Цагаан чулуут, Наран баг/ - гадна генераторыг холбоогүй, ус, дулаан дамжуулах төвийн дотор заслыг бүрэн дуусгаагүй ажлыг гүйцэтгэгчээр бүрэн гүйцэтгүүлж, хүлээн авах.
- 2025 онд ашиглалтад хүлээн авсан Ф720 мм-ийн дулааны төв шугамд өргөлтийн насосыг холбох арга хэмжээ авч ажиллах.

Хотын захирагчийн албанд:

- Төсөл, арга хэмжээ бүрээр баримт бичгийн сан үүсгэж, хяналт шалгалтын тоон мэдээллийг нэгтгэн тайлагнаж, удирдлагыг мэдээллээр хангах,
- Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг гүйцэтгэгчээр стандартын дагуу хийлгэж, байршуулан, олон нийтэд ил тод мэдээлсэн эсэхэд хяналт тавих.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг нэгтгэсэн тайланд тусгуулах саналыг уламжилж байна. Үүнд:

1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай уялдуулж тэнцүү хуваарилж төлөвлөж байх талаар төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөмж өгөх.

Холбогдох байгууллагын санал:



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 5590, Факс: (876) 7035 2621
Цахим шуудан: info@erdsnet.mn

2026.04.14 № 01/1345
тантай _____ -ны № _____ -т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан. Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно.

ЗАСАГ ДАРГА  Б.ЗОРИГТБАЯР

6126090512